

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 30-ны өдөр

№ 17

Улаанбаатар хот

Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дэх заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын журмын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.6.6, 3.8.1 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулан Rhinos asset management Хөрөнгө оруулалтын менежментийн компани болон Rhinos-KAI Хөрөнгө оруулалтын сан тус бүрээс 1,000,000,000 KRW (нэг тэрбум вон) буюу нийт 2,000,000,000 KRW (хоёр тэрбум вон), Сумьяа овогтой Түмэнгэрэлээс 2,000,000 ам.доллар (хоёр сая ам.доллар)-ыг тус тус хоёрдогч өглөг хэлбэрээр авч, Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан Хоёрдогч өглөгийн гэрээний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд Rhinos asset management Хөрөнгө оруулалтын менежментийн компани болон Rhinos-KAI Хөрөнгө оруулалтын сантай холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

4. Энэхүү тогтоолыг хэрэгжилтийг хангах, гэрээний үр дүнг ТУЗ-д эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАЙБАТ





ХОЁРДОГЧ ӨГЛӨГИЙН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Хоёрдогч өглөгийн нийт үнийн дүн	2,000,000,000 (хоёр тэрбум вон)	2,000,000 (хоёр сая ам.доллар)
Хөрөнгө оруулагч	Rhinos asset management Хөрөнгө оруулалтын менежментийн компани Rhinos-KAI Хөрөнгө оруулалтын сан	Сумьяа овогтой Түмэнгэрэл
Хугацаа	10 жил	3 жил
Хүүгийн хувь	Жил бүр 10%	13%
Нэмэлт өгөөжийн хувь	Тухайн жилийн цэвэр ашгийн 2%	-
Хүү ба нэмэлт өгөөжийн төлбөр	Жил бүр	Хагас жил тутам
Тогтоосон хугацаанд төлбөр төлөх нөхцөл (Put Option)	Хоёрдогч өглөг гаргаснаас хойш 5 дахь жилийн ойн өдрөөс эхлэн, хугацаа дуусах өдрийн өмнөх өдөр хүртэл хөрөнгө оруулагч жил бүрийн хүүгийн төлбөрийн өдөр энэ эрхээ хэрэгжүүлэх эрхтэй.	-

**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЭЧНЭЭ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар:10

Улаанбаатар хот

“СЭНДЛИ ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, хоёрдогч өглөгийн гэрээний нөхцөл батлах асуудлыг танилцуулах материал, гарах тогтоолын төслийн хамт гишүүдэд цахим шуудангаар эчнээ санал хураахаар хүргүүлж, энэ тухай утсаар мэдэгдсэн болно. Эчнээ санал хураалт нэгтгэх сүүлийн өдрийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоов.

Хэлэлцүүлсэн асуудлын тухай:

“Сэндли ББСБ” ХК нь хоёрдогч өглөг гаргах замаар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай

Хоёрдогч өглөгийн нөхцөл:

Хоёрдогч өглөгийн нийт үнийн дүн	2,000,000,000 (хоёр тэрбум won)	2,000,000 (хоёр сая ам.доллар)
Хөрөнгө оруулагч	Rhinos asset management Хөрөнгө оруулалтын менежментийн компани Rhinos-KAI Хөрөнгө оруулалтын сан	Сумьяа овогтой Түмэнгэрэл
Хугацаа	10 жил	3 жил
Хүүгийн хувь	Жил бүр 10%	13%
Нэмэлт өгөөжийн хувь	Тухайн жилийн цэвэр ашгийн 2%	-
Хүү ба нэмэлт өгөөжийн төлбөр	Жил бүр	Хагас жил тутам
Тогтоосон хугацаанд төлбөр төлөх нөхцөл (Put Option)	Хоёрдогч өглөг гаргаснаас хойш 5 дахь жилийн ойн өдрөөс эхлэн, хугацаа дуусах өдрийн өмнөх өдөр хүртэл хөрөнгө оруулагч жил бүрийн хүүгийн төлбөрийн өдөр энэ эрхээ хэрэгжүүлэх эрхтэй.	-

Б.Наранбат: Дэмжиж байна.

Бусад гишүүд: Дэмжиж байна.

Санал хураалтын дүн:

- ТУЗ-ийн хурлын санал хураалтад нийт 5 гишүүн саналаа өгч, шийдвэр гаргах ирц 55.5 хувь бүрдэж, санал хураалт хүчин төгөлдөр болов.
- Санал ирүүлсэн ТУЗ-ийн гишүүдээс татгалзсан санал ирүүлээгүй буюу саналаа ирүүлсэн гишүүдийн 100% хувь нь дэмжсэн санал өгсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:

Б.Наранбат /...../

Б.Эрдэнэ /...../

М.Цолмон /...../

Л.Нарантуяа/...../

Н.Билгүүн /...../

Тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн НБД  /Б.Мөнхцэцэг/